

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

МАЛ АЖ АХУЙН СЭДВИЙГ ТОГТМОЛ ХЭВЛЭЛД ТУСГАЖ ИРСЭН
УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД
(Монгол Улс болон ӨМӨЗО-ы тогтмол хэвлэлийн жишээн дээр)

С.Найрсаг*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант (ӨМӨЗО)

Түлхүүр үг: мал аж ахуй, нийтлэлийн сэдэв, бичлэгийн төрөл зүйл, нүүдэлчин ард түмэн, уламжлал ба шинэчлэл.

Мал аж ахуй нь умард Азийн өндөрлөг эх газарт нутагладаг нүүдэлчин ард түмний гол амьжиргааны эх үүсвэр, мөн улс орны эдийн засгийн хөгжлийн тулгуур хүчин зүйл болсны хувьд тогтмол хэвлэлийн чухал сэдвүүдийн нэг болсоор ирсэн юм. Монгол Улс болон ӨМӨЗО хоёулаа мал аж ахуйд түшиглэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлж ирсэн түүхтэй. Монгол Улс өдгөө хүртэл нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг бол Өвөр Монгол нь уламжлалт нүүдлийн мал аж ахуйтай байснаас 1990 оны сүүлчээс “Өрхөөр бэлчээр дааж авах” төрийн бодолгын дагуу суурьшил мал аж ахуйн бүтэц рүү шилжиж, дан малжих ороноос мал аж ахуй ба газар тариаланг хосолсон аж ахуйн системтэй болжээ.

Мал аж ахуйн асуудал нь Монгол Улсын тогтмол хэвлэлийн чухал сэдэв болох нь. Монголын сэтгүүл зүйн эх суурийг тавьсан ууган тогтмол хэвлэл болох 1913 оны 3-р сарын 6-нд анх гарсан “Шинэ толь хэмээх бичиг”

сонинд улс орны эдийн засгийн хөгжлийн талаар бичсэн санал санаачлагуудад “Монгол улс малаар баялаг болтугай” гэсэн өгүүлэлд монголчууд зөвхөн таван хошуу малынхаа ашиг шимээр амьдардаг бөгөөд мөн малаа гадагш худалдаж ашиг олз олох зам мөн магад гэмээн бичсэн байдаг. “Шинэ толь хэмээх бичиг” сонины үзэл санааг гүнзгийрүүлсэн 1915 оны 9-р сард гарсан “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинд улс орны амьдрал аж ахуйн сэдвийг тусгахдаа “Улс орны дотоодод хэрэгжүлбэл зохих 12 зүйлийн сануулга” гэсэн өгүүлэлд “Малаас гарах түүхий эд, арс шир, ноос үсийг сайтар ашиглах шаардлагатай”¹ гэж дурьджээ.

Ардын хувьсгалын эхний жилүүдийн “Уриа” сонинд монголчууд эртнээс харийн худалдаачдад малын түүхий эдээ маш хямд үнээр зарж байгаа үзэгдлийг өөрчлөн үндэсний хоршоолол байгуулах тухай санал гаргасан байв. Мөн улс орны санхүүгийн нөөцийг зузаатгахын тулд гааль татварын асуудлыг шийдэж, мал аж ахуйгаас татвар авах тухай мэдээлэл бичиж байв. 1922 оны 6-р сарын 22-ноос эхлэн гарагсан “Хураангүй

сэтгүүл”-д Монгол Улсын хүн ам, мал сүргийн тоо толгой, эдийн засгийн талаар мэдээлж байв. 1920 онд Оросын эрдэмтэн Майский Монголд бог мал 9.5 сая, адуу 1.5 сая, үхэр 1.4 сая, тэмээ 0.3 сая, бүх мал 12.7 сая гэсэн тооцоо гарагсан байдаг. Мөн 1923 оны “Нийслэлийн шинэ сонин”-д мал сүргийг боловсон эмнэлгээр эмнэж, өвчин тахлаас урьдчилан сэргийлэх, хашаа хороо, өвс усаар хангах, хариулга маллагааг сайжруулах нь тоо толгойг өсгөж, ашиг шимийг нэмэгдүүлэх үндэс хэмээн зааж байв.

1940-ээд оны үеийн радио нэвтрүүлэг улс орны аж ахуйн сэдэвтэй мэдээлэл түгээх цар хүрээ нэмэгдэж, малын төл бойжуулах, хашаа худгийн тоог олшруулах, сүү тос авах, өвс хадлан зэрэг хөдөө аж ахуйн цаг үеийн ажлын тухай мэдээ материал голлож байжээ. Тухайн үед сонин мэдээ түгээх зам харилцаа хөгжөөгүй байсан болохоор төвийн сонины мэдээг радиогоор уншдаг байв. Мөн 1940-өөд оны тогтмол хэвлэлүүд мал аж ахуйн сэдвээр бичихдээ мал маллагааны шинэ арга, технологийг зааж сургах, малчдын ажил үүргийг сурвалжлан бичих үндсэн хоёр хэлбэрийг ашиглаж байв. Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний жилүүдэд “Үнэн” сонин зөвхөн мал аж ахуйн сэдвээр 100 орчим өгүүлэл нийтэлж, мал аж ахуйн салбарт гарсан дэвшил, шинэ арга ухааны зэргийг бичлэгийн янз бүрийн хэлбэрээр мэдээлж байв.

1950-иад оны тогтмол хэвлэлийн гол тусгаж байгаа үндсэн агуулга нь социализмийг байгуулах тэмцлийг өргөнөөр сурталчлахын тулд аж үйлдвэр, мал аж ахуйн салбарын тэргүүний сайчуулын улсын зөвлөлгөөн зэрэг чухал арга хэмжээг голлон тусгаж байв. 1950 оноос эхлэн малын төл

бойжуулах ажлыг тусгах зорилготой “Мал-манай алтан фонд” нэрийн доор анхны сэдэвчилсэн цуврал нэвтрүүлэг бий болжээ. 1954 онд Монголын радио анх удаа хөдөөгийн малчнаас сурвалжлага авсан түүхтэй. 1955 оны “Үнэн” сонин Ардын үйлдвэрлэгчдийн нэгдлийн анхдугаар их хурлын дараа хөдөө аж ахуйн нэгдлийн тухай бичсэн өгүүлэлдээ уламжлалт мал маллагааны арга туршлагыг шинжлэх ухаан техникийн ололттой хослох хэрэгтэй гэж тайлбарлан бичжээ. 1953-1957 оны хоёрдугаар таван жилийн болон 1958-1960 оны 3 жилийн төлөвлөгөөнд хөдөө аж ахуйн талаар дэвшүүлсэн малын тоог өсгөх, малын чанарыг сайжруулах зэрэг талаар хэвлэл, радио өргөн сурталчилж байв.

Тухайн үед тогтмол хэвлэл нь мал аж ахуйн салбарын ололт амжилтыг мэдээлж, 1958-1960 он хүртэл гурван жилийн төлөвлөгөөг ханган биелүүлсэн тухай өргөнөөр сурталчилж байв. 1958 оны сүүлийн хагас жилд “Үнэн” сонин хөдөө аж ахуйн нэгдлийн ажил үйлсийг орон нутгийн хэвлэлд хэрхэн тусгаж байгааг харуулсан олон тойм бичиж, жишээ нь “Сүхбаатарын зам “сонинд малын ашиг шимийг нэмэгдүүлэх талаар хэрхэн тусгаж байгааг, мөн малын тэжээл бэлтгэх ажлыг “Ардын цэргийнхэн хадланд”, “Хэнтий аймгийн хадлангийн явц” зэрэг “Зунд эс суувал, зудад үл сандарна” гэсэн малгай гарчгийн доор мал аж ахуйн ажлыг байнга бичиж байв.

1961 онд хуралдсан МАХН-ын XIV их хурлын дараа хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хөдөө аж ахуй эдийн засгийн ололт амжилт, нэгдэлч малчдын тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх болон бусад нэгдлийн үйлдвэрлэлийн тухай мэдээлэл “Социалист хөдөө аж ахуй”

сонин зэрэг тогтмол хэвлэлийн чухал сэдэв болж байжээ. 1962 онд болсон мал аж ахуйн мэрэгжилтний улсын хоёрдугаар зөвлөлгөөнтэй холбогдуулан "Үнэн" сонин мал аж ахуйг шинжлэх ухаанч аргаар хөгжүүлэх тухай өгүүлэл нийтэлжээ. Мөн оны 5 сараас амжилт бүтээлээрээ олноо тэргүүлж яваа малчин, ажилчин, сэхээтэн зэрэг хүмүүсийг радио найруулал, сурвалжлага, уран нийтлэлийн хэлбэрээр олонд таниулж алдаршуулж байжээ. Жараад оноос Монгол Улсын тогтмол хэвлэл нь хөдөө мал аж ахуйн тулгамдсан асуудлыг тусгахдаа шинжлэх ухааны үндэстэй дэвшүүлдэг болсныг харуулж байна. "Үнэн" сонин нийтлэлийнхээ ихэнх хэсэгт хөдөө мал аж ахуйг удирдах, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, мал аж ахуйг хөгжүүлэх талаар бичдэг байлаа. 1963 онд "Үнэн" сонин малын төл хүлээн авахад зориулж 50 гаруй зөвлөлгөө, туршлага, өгүүлэл нийтэлж, "Малын төл нэг бүрийг бойжуулахын төлөө" гэдэг тогтмол булан гаргаж байжээ. ХМХ нь мал аж ахуйг хөгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг чухал нөхцөлийн талаар сурталчилж байв. 1968 оноос 1970 он хүртэл хэвлэл, радио мал аж ахуйн тэжээл, ус, хашаа саравч зэргээр хангах өөрчлөлтийг дэвшүүлж байв.

1970-аад онд тогтмол хэвлэл, радио, телевиз улс орны нийгэм, аж ахуйн амьдралд гарсан шинэ зүйлүүдийг тусгаж, мөн хөдөө орон нутагаар шинжлэх ухаанч маягаар малжсан

малчдын туршлагыг орон даяар хүргэж байв. 1970-аад оны сүүлч болоход ажилчин, малчин сурвалжлагч, идэвхтний тоо нэмэгдэж, үйлдвэрчний сонин, сэтгүүлчийн гол түшиг тулгуур болжээ².

1980-аад оны дундаас тогтмол хэвлэл, радио, телевизийн нэвтрүүлэгт өөрчлөлт шинэчлэл, ардчилал, олон ургалч үзэл, хүний эрх, ил тод байдал гэх мэт ойлголт түрэн орж ирснээр ХМХ нь улс төрийн мэдээлэл, маргаан мэтгэлцээн, шүүмжлэлт материал

зонхилж, үйлдвэр, хөдөө аж ахуй гэх мэт уламжлалт сэдэв харьцангуй ховор болжээ.

1990 оноос өнөөг хүртээл Монголын телевизийн дотор UBS TV, тогтмол хэвлэлээс "Өдрийн сонин", "Ардын эрх", "Өнөөдөр" зэрэг сонинууд мал аж ахуйн асуудлын талаар байнга

мэдээлдэг байв. Харин орон нутгийн сонин 1990-ээд онд захиалагчгүй болж, гаралтаа зогсооход хүрч байжээ.

Мал аж ахуйн салбарын мэдээллийн гол эх үүсвэр нь малын жил бүрийн тооллого байдаг. Жил бүрийн 12 сарын 7-17-ны хооронд Монгол Улс даяар мал тооллого зохион байгуулагдаж тогтмол хэвлэлийнхний гол сэдэв болдог юм.

Орчин үед телевизийн "Малчин" суваг, "Молор", "Сүлд" зэрэг телевиз нь мал аж ахуйн талаар мэдээлж байдаг. Мөн "Өдрийн сонин", "Өнөөдөр" сонин зэрэг тогтмол хэвлэлээс гадна мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй эрх зүйн баримт бичигт Монгол Улсын хууль,

«

1980-аад оны дундаас тогтмол хэвлэл, радио, телевизийн нэвтрүүлэгт өөрчлөлт шинэчлэл, ардчилал, олон ургалч үзэл, хүний эрх, ил тод байдал гэх мэт ойлголт түрэн орж ирснээр ХМХ нь улс төрийн мэдээлэл, маргаан мэтгэлцээн, шүүмжлэлт материал зонхилж, үйлдвэр, хөдөө аж ахуй гэх мэт уламжлалт сэдэв харьцангуй ховор болжээ

»

УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол нь ХХААХҮ-ийн яамны mofa.gov.mn сайтад тогтмол нийтлэгддэг байна. Мөн ikon.mn, 1212.mn, ezone.mn, trends.mn, news.mn, gogo.mn зэрэг сайтуудад МАА асуудалтай холбоотой мэдээ мэдээллийг нийтэлдэг.

Монгол Улсын тогтмол хэвлэл дотроос уншигчийн тоогоор тэргүүлдэг “Өдрийн сонин”-ы 2017 оны бүх дугааруудад судалгаа хийж үзэхэд мэдээ, хөрөг найруулал, ярилцлага, сурвалжлага, өгүүлэл, тойм, шүүмж, тэмдэглэл, захидал зэрэг бараг бүх бичлэгийн төрөл зүйлээр байгалийн гамшиг, малын эрүүл мэндийн асуудал, малын ашиг шим ба зах зээл, төрийн бодлого, хууль төслийг дамжуулах, малчдын нийгмийн хамгаалал болон татвар, зан үйл, мал аж ахуйн загвар судалгаа зэрэг асуудлыг тусгаж, мал аж ахуйн асуудлыг олон талаас нь харуулсан нь энэ асуудал бол тогтмол хэвлэлийн чухал сэдэв болох нь харагдаж байна. Найруулга зүйн хувд нийтлэлийн өнгө аяс давагмайлаж, уянгын халил багатай, гадаад үг хэллэг их орсон зэрэг ажиглагдсан юм.

Мал аж ахуйн асуудал нь ӨМӨЗО-ы тогтмол хэвлэлийн чухал сэдэв болох нь. Өвөр Монголын тогтмол хэвлэлийн түүх нь орчин үеээс (1921-1947) үүсэлтэй гэж үзэдэг. Энэ хугацаанд Өвөр Монголд нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотой олон сонин сэтгүүл гарч байжээ. Энэ хугцааг төлөөлөх чанартай, нөлөө ихтэй сонинуудаас мал аж ахуйн асуудлыг тусгаж байсан нь доорхи хэдэн сонин байна.

1925 оны 4 сарын 28-нд “Монголын тариаланч ард” хэмээх анхны хувьсгалт сэтгүүл гарч, фео-

далын эсрэг малчин тариачны ангийн ухамсрыг дээшлүүлэх, цэргийн эрхтний бэлчээр нутаг эзэлж атар хагалбарлаж байгааг эсэргүүцэн нутаг бэлчээрээ хамгаалахыг уриалсан, Мүн ван гүн нарын малчдыг мөлжин даралж байгаа үнэнийг илчилсэн агуулгатай байв. “Монгол хошуунд тархаах арван өдрийн дармал” сонин нь 1924-1931 оны хооронд гарч, Өвөр Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлд үндсэн чанарын өөрчлөлт гараагүй мөртлөө хятад тариачид бэлчээр хагалбарласнаас болж малчдын амьдарл доройтсон тухай бичсэн байдаг. Дундад иргэн улсын 18 онд гарсан “Монгол Төвдийн долоон өдрийн сэтгүүл”-д Өвөр Монголын ахуй амьдарлын талаар “Монгол орон бол элс манхан ихтэй, уур амьсгал хүйтэн, хур бороо ховор болохоор тариаланд ашиггүй, иймээс монголчууд ус бэлчээр дагаж оторлон малждаг тул амьдарлын хэрэгслээ өөрөө үйлдэврлэж чадахгүй, малын ашиг шимээ өөрөө боловсруулж чадахгүй”³ гэж бичиж байжээ.

1949 онд БНХАУ, мөн 1947 онд Өвөр Монгол Үндэстний өөртөө засах орон болсноор үндэстний сэтгүүл зүй хөгжиж эхэлжээ. Өвөр Монголын Шилийн гол аймаг 1947 оны 7-р сарын 1-ний өдөр “Шилийн Голын өдрийн сонин”-ы анхны дугаараа хэвлэн гаргаснаас хойш “Малчдын сонин” гэж нэрлэгдэж, малчин түмний аж амьдрал, мал аж ахуйн асуудлыг үндсэн сэдэв болгожээ. 1950-60-аад оны “Өвөр Монголын өдрийн сонин”, “Хөлөнбуйрын өдрийн сонин”, “Шилийн голын өдрийн сонин”, “Ордосын сонин”, “Жуу удын сонин”, “Жиримийн сонин”, “Баяаннуурын сонин” зэрэг орон болон аймгийн дэсийн сонинууд гарч эхэлсэн боловч 1966-1976 онуудад бүтэн 10 жилийн турш өрнөсөн Соёлын

хувсгалын үед ихэнх монгол сэтгүүл хаагдсан бөгөөд зарим сонин нь хятад сонины орчуул-гын хэвлэл болсон байжээ.

Соёлын хувсгалын дараа өөрчлөлт нээлтийн 30 жилийн турш Өвөр Монголын сэтгүүл зүй нь бусад цөөн тооны үндэстний сэтгүүл зүйн хөгжилтэй харьцуулбал харьцангуй сайн хөгжиж эхэлсэн. Монгол сонин бол монгол үндэстний үсэг бичгээ хадгалж байгаа цөөн тоот үндэстний орны намын сонин юм. Эв хамт намын 11 дүгээр хугцааны III бүгд хуралдаанаас хойш үндэстний хэл бичгийн ажил шинэ хөгжлөө олж, малчин түмний оюуны эрэлт хэрэгцээ болон мал аж ахуйн хөгжлийн төлөө монгол сонин сэтгүүл хичээх болжээ.

1982 онд Шинжианы Бортал тойргийн “Бортал сонин”-ы дэргэд Монгол найруулах анги байгуулагдаж, тариалан, малжих орны ухуулгыг чухалчилж, намаас хөдөө тосгон малжих оронд төрийн бодлого, шинжлэх ухаанч аргаар мал хариулах, зах дэлгүүрийн үзэл бий болгох зэрэг намын бодлогын дагуу сониноо эрхэлж байв.

Телевиз, радио, интернет хөгжсөн өнөө цагт мал аж ахуйн асуудлыг тусгах арга хэлбэр өргөжиж, Төвийн намын хорооноос малчин түмэн буюу үндэстний аж ахуйд анхаарал халамж тавих арга зам нь улам илүү дөхөм дөт болжээ.

Өвөр Монголын “Одон” телевизийн “Одон мэдээ”, “Соёл-Эрдэнэ”, “Хуулийн хөтөч”, аймаг хошууны телевиз зэрэг мал аж ахуйн асуудлыг тусгасан нэвтрүүлгүүд цөөнгүй байна. “Өвөр Монголын Одон мэдээ” нь өдөр бүр Өвөр Монголын аймаг хошуудын малчин түмний аж амьдрал, орлого зарлагын талаар хураангуйлсан товч

болон нам төрийн мал аж ахуйтай холбоотой хууль төслийг хүргэдэг юм.

Өвөр Монголын радио хорооны “Малчин тариачны хань” нэвтрүүлэг, Төвийн ардын радио нэвтрүүлэг зэрэг нь малжих, тариалах хөдөө орон нутгаар сэтгүүлч томилон тухайн газрын байдлыг ойлгон, малчдын ашиг тусыг хамгаалах зорилгоор сэтгүүлчтэй шууд утсаар холбогдон мэдээлэл хүргэдэг юм.

Мөн мал аж ахуйтай холбоотой тогтмол хэвлэлийн тоонд “Өвөр Монголын өдрийн сонин”, “Амьдрал гараг” сонин, аймаг хошууны өдрийн сонин, Шилийн голын ажил мэргэжлийн дээд сургуулийн “Монгол адуу” сэтгүүл, “Үйлдлэг” сэтгүүл, “Өвөр Монголын мал аж ахуйн сэтгүүл”, “Өвөр Монголын Тариалангийн их сургуулийн сэтгүүл” зэрэг сонин, сэтгүүл зүй ёсоор багтдаг. “Өвөр Монголын мал аж ахуйн сэтгүүл” бол Өвөр Монголын цор ганц мал аж ахуй технологийн тухай тогтмол бичдэг сэтгүүл төдийгүй бүх улсын хэмжээнд сүлжээн дээрээс хайлт хийж болдог интернет сэтгүүл юм. Эл сэтгүүл нь 1980 онд анх гарснаас аваад дотоод, гадаадын мал аж ахуйн хөгжлийн талаар танилцуулж, малчин түмэнд шинжлэх ухаанч зөв арга замыг зааж өгдөг томоохон ач холбогдолтой нөлөө бүхий тогтмол хэвлэл юм.

Интернет орчинд нэвтэрч эхэлж байгаа малчид өнөөдөр уламжлалт ХМХ-ээс гадна гар утсан дээрээ малчдын ашиг сонирхлын дагуу бий болсон сүлжээ холбоог ашиглан шинэ мэдээг цаг тухайд нь хүлээн авдаг болжээ. Малчдын үргэлж хэрэглэдэг сайтуудын тоонд “Холбоо сүлжээ”, “Ардын сүлжээ”, “Вики ухаан”, “Монгол сонин мэдээ”, “Малчин сүлжээ” зэрэг сайт багтдаг байна.

Өвөр Монголд тогтмол хэвлэлийн хувьд хамгийн олон уншигчтай “Өдрийн сонин”-ы 2017 оны бүх дугааруудаас ажигласнаар мал аж ахуйн асуудалтай холбоотой нийтлэл нь голдуу мэдээ, хөрөг найруулал, ярилцлага, сурвалжлага, шүүмж зэрэг бичлэгийн төрөл зүйлээр малчдын амьдрал ахуйн асуудлыг голлон тусгасан байна. Нийтлэлийн өнгө аяс багатай, уран зохиолын үг хэллэг их зэрэг онцлогтой байгаа нь ажиглагдсан.

Нийтлэлийн гол сэдэвт Өвөр Монголын мал аж ахуйн түүх, малын эрүүл мэндийн асуудал, малын ашиг шимийг хэрхэн ашиглаж байгаа, малчдын амьдарлын түвшин буюу жилийн орлого зарлагын байдал, малчдын нийгмийн хамгаалал, малчдын хөрөг бүтээх, мал аж ахуйтай холбоотой төрийн хууль төслийг дамжуулах, шинэ цаг үеийн технологи болон зам харилцааны талаар ухуулан сурталчлах, мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ирээдүйн хөгжлийн хандлага, малын тооллого бүртгэл, хувийн аж ахуйн сэргэлт, байгалийн гамшгийн талаарх мэдээлэл, нийгмийн боловсон хүчин зэрэг олон асуудал багтсан байна.

Дүгнэлт. Хоёр орны тогтмол хэвлэл үүсч эхэлсэн цагаас эхлэн мал аж ахуй болон малчны аж амьдарлын асуудалд гол анхаарлаа хандуулж, өнөөдөр хүртэл төр засаг, нийгэм, олон нийтийн анхаарлын төвд байсаар байна. Мал аж ахуй нь монголчуудын түүхэн уламжлалт аж ахуйн хэлбэр болсны хувьд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой чухал нөлөө бүхий салбар гэдэг нь тодорхой юм. Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг нь, Өвөр Монголын нийт хүн амын 42.75% нь мал аж ахуй эрхэлж, мөн энэ салбартай холбоотой маш олон дагалт

салбарууд нь улсын эдийн засгийн орлогод нөлөөлж байдаг болохоор хоёр орны тогтмол хэвлэлийн чухал сэдэв болсоор иржээ. Нийтлэлийн хувьд тодорхой хэмжээнд малчдын үнэн бодитой амьдралыг тусгаж, мал аж ахуйн салбарын туршлагыг дүгнэж, алдааг залруулан, ирээдүйн хөгжил дэвшилд нөлөөлж чаддаг нь тодорхой харагдаж байна.

Ишлэл

1. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть.УБ. х.142.
2. Норовсүрэн Л. 2012. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть.УБ. х.354.
3. Төгсцогт, Ван шиү лан. 1999. Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм. Хөххот. х.334.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2016. Сэтгүүл зүйн тайлбар толь. Хөххот.
2. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть.УБ.
3. Норовсүрэн Л. 2012. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть.УБ.
4. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
5. Өвөр Монголын сонин мэдээний ажилчдын нийгэмлэг. 2009. Дундад Улсын Монгол сонины үйлдвэр. Хөххот
6. Төгсцогт, Ван шиү лан. 1999. Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм. Хөххот.

Резюме

В этой статье автор рассматривает вопросы формы и подачи, традиции и обновления освещения темы сельского хозяйства, в том числе скотоводства в периодической печати Монголии и Внутренней Монголии КНР. Автор анализируя эти вопросы на основе исторических фактов и публикаций СМИ делает вывод о том, что вопросы скотоводства и земледелия являются основной и очень важной темой периодической печати двух стран и важным фактором, определяющим качество газетных материалов и мастерство журналистов СМИ.